

ГАРЧИГ

<i>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа	5
1.3. Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт	6
1.4. Баяжуулалтын технологи	6
1.5. Хаягдлын сангийн тооцоо	7
1.6. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц.....	8
1.7. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө.....	8
<i>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	12
<i>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ</i>	14
3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж	14
3.2 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим	14
<i>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</i>	15
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
4.2. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	20
4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	21
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	21
4.7. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	21
4.8. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	22
4.9. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....	23
4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	23

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт.....	3
Хүснэгт 2. Төсөл хэрэгжих талбайн солбилцол.....	4
Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим.....	5
Хүснэгт 4. Далд уурхайн календарчилсан төлөвлөгөө	5
Хүснэгт 5. Далд уурхайн тоног төхөөрөмжүүд	6
Хүснэгт 6.Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлын төлөвлөлт	6
Хүснэгт 7. Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө	7
Хүснэгт 8. Уурхайд хэрэглэгдэх усны хэрэгцээ.....	10
Хүснэгт 9. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа,эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялах нь.....	14
Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....	17
Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт 12. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
Хүснэгт 13. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 14. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 15. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	22
Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	23
Хүснэгт 19. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь	23

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1: Төсөл хэрэгжих талбайн байриил.....	4
Зураг 2. Хүдэр баяжуулах технологийн схем.....	7

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт


№	Үзүүлэлт	Х.нэгж	Дүн
1	Төсөл хэрэгжүүлэгч компани		“Түмэн-Ивээл” ХХК
2	Компанийн улсын бүртгэлийн дугаар		9019099600
3	Тусгай зөвшөөрлийн дугаар		MV-015580
4	Ашигт малтмалын төрөл		Гянтболд
Геологийн нөөц (C зэргээр)			
4	Анх батлагдсан нөөц	мян.т	54.67
4.1	Хүдрийн нөөц. Боломжтой (C)	мян.т	54.67
Үйлдвэрлэлийн нөөц			
5	Далд уурхайн хүрээнд хамаарах нөөц	мян.т	53.12
6	Далд уурхайн ашиглалтын технологи		Скреперийн тээвэртэй баганат камер
7	Хүчин чадал	мян.т	25.0
8	Далд уурхайн үйлдвэрлэлийн (B') нөөц	мян.т	44.59
9	Далд уурхайн ашиглалтын хаягдал	%	19.9
10	Далд уурхайн ашиглалтын бохирдол	%	4.96
11	Хүдрийн эзлэхүүн жин	т/м ³	2.65
12	Орд ашиглалтын хугацаа	жил	2
13	Цахилгааны эх үүсвэр		Өөрийн эх үүсвэр
14	Усан хангамжийн эх үүсвэр		Унд ахуйн ус-гүний худаг, Технологийн ус-эргэлтийн
Эдийн засгийн хэсэг			
15	Борлуулах үнэ /60 %-ийн агуулгатай баяжмал/	сая.төг/т	213
16	Борлуулалтын орлого (ордын нийт)	сая.төг	32,045.53
17	Нийт зардал (ордын нийт)	сая.төг	23,980.22
18	Татварын өмнөх ашиг (ордын нийт)	сая.төг	8,065.30
19	Татварын дараах цэвэр ашиг (ордын нийт)	сая.төг	7,258.77
20	Бүрэн өөрийн өртөг	төг/т	159,391.60
21	Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	5,706.08
22	Өнөөгийн үнэ, цэнэ NPV 10%	сая.төг	2,464.63
23	Өнөөгийн үнэ, цэнэ NPV 15%	сая.төг	1,891.61
24	Өгөөжийн дотоод норм, IRR	%	37.4
25	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	жил	1.4
26	Улсын төсөвт оруулах татвар, төлбөр (ордын нийт)	сая.төг	6,854.23
27	Нийт ажиллагсдын тоо	хүн	135
28	Нэг ажилчны сарын дундаж цалин	мян.төг	3,441

Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:

“Буянт” гянтболдын орд нь засаг захиргааны нэгжийн хувьд Хэнтий аймгийн Галшар сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 330 км, Галшар сумаас зүүн зүгт 18 км зайд тус тус байрлана. Талбай нь номенклатурын хувьд L-49-067 хавтгайд байрладаг.

Хүснэгт 2. Төсөл хэрэгжих талбайн солбицол

Т.З дугаар	Цэгийн дугаар	Газарзүйн солбицол	
		УРТРАГ	ӨРГӨРӨГ
MV-015580	1	111° 06' 19.99"	46° 14' 41.65"
	2	111° 06' 19.99"	46° 15' 56.65"
	3	111° 05' 29.99"	46° 15' 56.65"
	4	111° 05' 29.99"	46° 15' 31.65"
	5	111° 04' 16.99"	46° 15' 31.65"
	6	111° 04' 16.99"	46° 14' 41.65"



Зураг 1: Төсөл хэрэгжих талбайн байршил

1.2. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа

Уурхайн жилийн хүчин чадал

Уурхайн хүчин чадлыг захиалагч байгууллагаас өгсөн төслийн даалгаврыг үндэслэн жилд 25.0 мян.тн хүдэр олборлохоор төсөлд тусгав.

“Буянт” гянтболдын ордыг далд уурхайн аргаар ашиглах хэдий ч төслийн захиалагч талын өгсөн техникийн даалгаврын дагуу уулын ажлыг жилд 3-р сарын 01-ээс 11-р сарын 30 хүртэл ажиллуулахаар төлөвлөлөө. Жилд ажиллах хоногийн тоо 260 байна.

Уулын ажлыг далд уурхайд 10 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллахаар сонголоо.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим

№	Үндсэн ажиллагаа	Хэмжих нэгж	Ажиллах хоног
1	Хуанлийн өдөр (3.01-11.30)	Хоног	275
2	Баяр ёслолын амралт	Хоног	11
3	Бэлтгэл ажил	Хоног	4
4	Жилд ажиллах хоног	Хоног	260
5	Хоногт ажиллах ээлж	Ээлж	2
6	Ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	10

Хүснэгт 4. Далд уурхайн календарчилсан төлөвлөгөө

Далд уурхайн календарчилсан төлөвлөгөө										
Хүдрийн биет	Блокийн дугаар, ашиглалтын	Нөөцийн зэрэг	1-р жилд				2-р жилд			
			Хүдрийн нөөц		Металлын агуулга, %	Металлын хэмжээ, тн	Хүдрийн нөөц		Металлын агуулга, %	Металлын хэмжээ, тн
			мян.м³	мян.тн			мян.м³	мян.тн		
2-р хүдрийн биет	Бл-0	С	0.88	2.32	0.20	4.63				
	Бл-1	С	2.07	5.47	0.39	21.47				
	Бл-2	С	0.45	1.19	0.40	4.74	1.70	4.52	0.40	18.02
	Бл-3	С					2.43	6.44	0.36	23.00
	Бл-4	С					0.71	1.89	0.19	3.58
	Бл-5	С	0.87	2.31	0.19	4.36				
	Бл-6	С	0.92	2.43	0.19	4.60				
	Бл-7	С	0.71	1.87	0.19	3.54	0.30	0.80	0.19	1.52
	Бл-8	С					1.25	3.32	0.19	6.29
	Бл-9	С					0.90	2.38	0.19	4.50
	Бл-10	С					0.42	1.11	0.19	2.10
	Бл-11	С					0.23	0.61	0.19	1.15
	Бл-12	С					1.49	3.95	0.19	7.50
	Бл-13	С	0.97	2.58	0.19	4.87				
	Бл-14	С	0.46	1.21	0.19	2.28				
	Бл-15	С	0.07	0.20	0.19	0.37				
Нийт С нөөц			7.39	19.59	0.26	50.87	9.43	25.00	0.27	67.65

1.3. Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт

Хүснэгт 5. Далд уурхайн тоног төхөөрөмжүүд

№	Техник, тоног төхөөрөмж	Марк	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Утга	Ажлын зориулалт
Далд уурхайн техник, тоног төхөөрөмжүүд						
1	Далд уурхайн утгуурт ачигч	Shandong XD928	2	м³	0.8	Хүдэр ачилт
2	Далд уурхайн автосамосвал	JH-10	6	тн	3.9	Хүдэр тээвэрлэлт
3	Скрепер	2 JP(B)-15	6	м³	0.08	Хүдэр тээвэрлэлт
4	Перфоратор	YT-28	16	мм	27	Далд уурхайн өрөмдлөг
5	Ерөнхий агааржуулалтын вентилятор	XH-MF30-4-45	3	м/сек	12	Агааржуулах
6	Хэсэгчилсэн агааржуулалтын вентилятор	YBT52-2	6	м/сек	6.4	Агааржуулах
7	Бетон шүршигч машин	PZ-50	1	-	-	Бэхэлгээ
8	Компрессор	ALS-75A	2	м³/мин	46.5	Хийн хангамж
9	Усны насос	ЦНС10-105	2	м³/цаг	10	Ус татах
10	Калорифер	HK200	2	Цельс	2	Дулаан дамжуулах
-	Дүн	-	46	-	-	-

1.4. Баяжуулалтын технологи


Баяжуулах үйлдвэр нь хоногт 112 тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай 2 ээлжээр ажиллана. Ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг. Баяжуулах үйлдвэрийн цаг ашиглалтын коэффициентийг 80 % байхаар төлөвлөж үндсэн үзүүлэлтүүдийг тооцсон.

Баяжуулах төхөөрөмж БНХАУ -д үйлдвэрлэсэн байгаль орчинд үзүүлэх хор нөлөөгүй, бусад төрлийн төхөөрөмжөөс давуу сайн талтай, ажиллах зарчим хялбар, эрчим хүч зарцуулалт бага зэрэг онцлогтой. Баяжуулалтын ажлын горимыг 7 сар буюу (3 сараас 10 сарын дуустал) 247 хоногоор тооцов.

Баяжуулах цех нь жилд 247 хоног өдөрт 2 ээлж, 10 цагаар тасралтгүй ажиллана.

Хүснэгт 6. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлын төлөвлөлт

№	Үзүүлэлтүүд	Баяжуулах үйлдвэр
1	Жилийн хуанлийн өдрийн тоо	365
2	Жилийн хуанлийн сар	12
3	Жилийн хуанлийн цаг	5840
4	Өдрийн хуанлийн цаг	16
5	Төлөвлөгөөт засварын хоног	8
6	Баяр ёслолын хоног	8
7	Цаг агаарын саатал	4
8	Өвлийн улиралын сул зогсолтын хоног	90
9	Урсгал засварын хоног	8
10	Жилд ажиллах бодит өдөр	247
11	Жилд ажиллах бодит цаг	3952
12	Үйлдвэрийн цаг ашиглалт, %	90
13	Жилд ажиллах бодит цаг	3557
12	Сард ажиллах бодит цаг	296
15	Цагийн хүчин чадал, тн/цаг	7.03
16	Хоногийн хүчин чадал, тн/хоног	112
18	Сарын хүчин чадал, тн/сар	2083
19	Жилийн хүчин чадал, тн/жил	25000



Зураг 2. Хүдэр баяжуулах технологийн схем

Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо:

Буянтын гянтболдын ордын нийт үйлдвэрлэлийн нөөц нь 44.59 мян.тн, 0.27% агуулгатай хүдэр дэх гянтболдын хэмжээ 118.5 т WO₃ байна. Үүнийг гравитацийн аргаар баяжуулж, 75.97 хувийн металл авалттайгаар нийт төслийн хугацаанд 60 %-ийн агуулгатай 150.5 т WO₃-ын баяжмал үйлдвэрлэнэ.

Хүснэгт 7. Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө

Жилүүд	Баяжуулах хүдрийн хэмжээ			Гарц %	Марк	Баяжуулсан хүдэр		
	Хүдэр, тонн	агуулга, %	Металл, т			Хүдэр, тонн	агуулга, %	Металл, т
1 дэх жил	19,590.54	0.26	50.87	100.00	Нийт	19,590.5	0.26	50.87
			-	0.34	Баяжмал	66.1	60.00	39.66
			-	99.66	Хаягдал	19,524.4	0.07	12.75
2 дахь жил	25,000.00	0.27	67.65	100	Нийт	25,000.0	0.27	67.65
			-	0.34	Баяжмал	84.4	60.00	50.61
			-	99.66	Хаягдал	24,915.6	0.06	15.81
Бүгд	44,590.54	0.27	118.51	100.00	Нийт	44,590.5	0.27	118.83
				0.34	Баяжмал	150.5	60.00	90.27
				99.66	Хаягдал	44,440.1	0.06	28.56

1.5. Хаягдлын сангийн тооцоо

Байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор олон улсын стандарт, Монгол улсын дотоодод мөрдөгдөж байгаа шаардлагын дагуу хаягдлын сан, хаягдлын аж ахуйг байгуулах юм. Хаягдлын сан байгуулахдаа эхлээд үржил шимтэй бор шороон хөрсийг хуулан авч, сүүлд нь нөхөн сэргээлтэд хэрэглэх буюу шим багатай орчны хөрсийг тордоход хэрэглэнэ.

Талбайн сонголт

Хаягдлын талбай нь баяжуулах цехээс урагш 100 гаруй м-т оршино. Ашиглагдсан хүдрийн овоолго нь тунгаагуурын нууранд байна. Баяжуулалтаас гарсан хүдэр нь урсаж байгаа усаар хөөгдөн, газрын налууг даган нууранд очно. Тунгаагуурын нууранд хаягдал хүдэр үлдэж, цэвэршсэн ус нь хальж цэвэр усны нууранд орно.

Хамгаалалтын далан ба суурийн хамгаалалтын тооцоонууд

Хаягдлын сан, аж ахуйн эргэн тойронд далан байгуулах ба ёроолыг нь жижиг ширхэглэлтэй чулуу буюу шавраар уллаж усны алдагдлаас сэргийлнэ. Хаягдлын санд хуримтлагдсан усыг хэд хэдэн секц дамжуулан тунгаан цэвэршүүлж, буцаан хэрэглэнэ. Бороо, цасны уснаас хаягдлын сан дүүрч халихаас сэргийлж нэмэгдэл ус зайлуулах шуудуу байгуулна.

Хаягдлын сангийн далангийн өндрийг усны гадаргын түвшингээс 1.5 м жигд өндөртэй байхаар хийнэ. Технологийн усан хангамжинд ЭЦВ маркийн насостой гүний худаг ашиглана. Технологийн усан хангамж нь:

- ✓ 20400 м³ /85*40*6/ багтаамжтай тунаах нуур
- ✓ 1800 м³ /20*15*6/ багтаамжтай эргэлтийн буюу цэвэр усны сан.
- ✓ Цэвэр усны санд байрлуулсан насос
- ✓ 150 м урт ус дамжуулах хоолой
- ✓ Ус хуваарилах, тохируулах системээс бүрдэнэ.

Цэврийн ба тунаах нуурын түвшин нь үер борооны усаар дүүрч, хяналтын түвшинд хүрсэн тохиолдолд цэвэр ус сэлбэлтийг зогсоох ба илүүдэл ус нь халигчаар гадагшилна. Усны нөөцийг хэмнэх, зөв зохистой ашиглах үүднээс нийт эргэлтийн усны 70.36 %-ийг эргэлтийн усаар хангах боломжтой юм.

Тунаах нууранд ашиглалтын хугацаанд хаягдах хаягдлын хэмжээг $44044.2/2.65 \text{ м}^3=16620 \text{ м}^3$ байна. Энэ нь тунаах нуурын эзлэхүүнээс бага $16620 < 20400$ нөхцлийг хангаж байна. Ажил дууссаны дараа нуурын ус шавхарч, хатсаны дараа хаягдлыг хөрсний чулуулаг болон шимт хөрсөөр хучилт хийж нөхөн сэргээнэ.

1.6. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц

1.6.1. Барилга байгууламж

Далд уурхай, баяжуулах хэсгийг түшиглэн уурхайн оффис, засварын газар, хоолны газар зэрэг барилга байгууламжууд баригдана. Ажилчдын тосгон нь уурхайн баруун хойд талд, баяжуулах хэсгийг уурхайн хойд талд, тэсрэх материал, хэрэгслийн агуулахыг уурхайгаас баруун урагш 1200 м зайд байрлуулахаар төлөвлөлөө.

Уурхайн кемп: Уурхайн кемп нь уурхайн захиргаа удирдлагын байр, ажилчдын амралтын байр, цайны газар, угаалга, ариун цэврийн газар зэрэг барилга байгууламжуудаас бүрдэнэ. Уурхайн барилга байгууламжууд нь шаардлагатай тавилга, эд хогшлоор бүрэн хангагдсан сэндвичэн хийцтэй байхаар тооцож төсөлд тусгалаа.

Холбооны байгууламж: Уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн операторууд болон бусад хэсгийн ажилчид богино долгионы радио холбоогоор хангагдана.

Түлшний агуулах: Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангана. Түлшний агуулах нь ойролцоогоор ил уурхайн 20 хоногийн түлшний хэрэглээ буюу 25 т түлш хадгалах, нөөц үүсгэх багтаамжтай байна. ШТС буюу түлшний агуулах нь шахуурга болон шүүлтүүртэй байна. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах, аянга зайлуулагч хэрэгслүүдтэй байна.

Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийх шаардлагатай бөгөөд төсөлд тус ажлын хөрөнгийг нэмж тооцлоо.

Засварын талбай: Уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг үйлдвэрийн талбайд байрлах засварын газар хийж гүйцэтгэнэ. Засварын газарт дугуй засвар, гагнуур, компрессорын станц зэрэг шаардлагатай багаж, хэрэгслээр хангагдсан байна.

Тэсрэх материалын агуулах: Уурхайн талбайгаас баруун урд талд тэсрэх материал, хэрэгслийн агуулахыг барихаар төлөвлөсөн. Агуулах нь үер усны шуудуугаар хамгаалагдсан төмөр торон хашаагаар хүрээлэгдсэн талбайд байрлах ба шалгах пункт, харуулын байр зэргийг барьж байгуулна. Агуулахыг тойруулан хамгаалалтын шороон далан байгуулж, аянга зайлуулагчаар тоноглоно.

1.6.2. Уурхайн усан хангамж

Уурхайн ус таталт

Ордын хайгуулын ажлын явцад Гүний усны түвшингийн улирлын чанартай өөрчлөлт ажиглагдаагүй. Цооног 3,6,4-өөр хийгдсэн судалгаагаар усжилт багатай бөгөөд ундарга нь 0.2-0.4 л/сек бөгөөд энэ нь 10-18 м хүртэл гүнд хамаарна.

Ус шавхалтаас хойш 5-9 цагийн дараа усны түвшин 1.5-13.3 м нэмэгдсэн. Буянтын хэсгийн гүний ус нь натрийн, натри-магнийн гидрокарбонат, хлорид-гидрокарбонат, гидрокарбонат-сульфатын төрөлд хамаарна.

Мөргөцөгөөс шүүрэн гарах усыг өөрийн нь урсгалаар усны шуудуугаар урсгаж, налуу амны дэргэд байрлах ус цуглуулах санд /зумпф/ хуримтлуулна. Энд насосны станц байх бөгөөд усан санг усаар дүүрсэн үед соруулж, газрын гадаргад шахаж, гаргана. Уурхайн ус таталтын аж ахуй нь гол насосны төхөөрөмж, ус дамжуулах хоолой, урсгах ба шүүрүүлэх суваг, ус хураагуур зэрэг байгууламжуудтай байна. Гол насосны төхөөрөмж нь уурхайн их амны ойролцоо тусгай камерт байрлана. Камерт 2 насос байрлуулах ба нэг нь ажилд, нөгөө нь нөөцөд байхаар тооцоолон ээлжлүүлэн ажлуулна. Насосыг хоногийн усны гарцыг тооцон үзэж түүнийг 20 цагаас илүүгүй хугацаагаар ажиллуулахад гарч буй усыг бүрэн татаж байхаар бүтээмжтэй насос сонгож авна.

Уурхайд хэрэглэгдэх усны хэрэгцээ

Уурхай нь унд ахуй, баяжуулах технологи, зам талбайн усалгаа болон ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар ус ашиглах ба уг хэрэгцээг өөрийн эзэмшлийн 3 ш гүний худгаас хангахаар төлөвлөсөн.

Баяжуулах үйлдвэрт технологийн усныхаа 70.36 %-ийг эргүүлэн ашиглах бүрэн боломжтой ба баяжуулах ширээнээс гарсан хаягдлыг тунаах даланд тунгааж, цэвэршүүлэх технологийн усан санд хуримтлуулан эргүүлэн ашиглана.

Хүснэгт 8. Уурхайд хэрэглэгдэх усны хэрэгцээ

№	Үзүүлэлт	Норм	Хэмжээ	Хоног	Хоногийн усны хэрэглээ, м³	Жилийн усны хэрэглээ, м³	Норм
1	Унд ахуйн болон хэрэглээний ус	80 л/хоног	69 хүн /нийт ажилчин/	260	5.52	1435.2	А/301 дугаар тушаалын 12-р хавсралт
2	Технологийн ус	2.8 м³/тн	25000	247	85.02	21000.0	А/301 дугаар тушаалын 2-р хавсралт
3	Зам талбай	2 л /м²	5560 м²	10 удаа	2.22 /1 удаагийн усалгааг 5 өдөрт хувааж усална/	111.2	А/301 дугаар тушаалын 13-р хавсралт
4	Ногоон байгууламж	40 л/ш	500	10 удаа	4.0 /Өдөрт 100 ш мод услана/	200.0	А/301 дугаар тушаалын 13-р хавсралт
Нийт дүн					96.76	22746.4	

Төслийн хүрээнд хоногт 96.76 м³, жилд 22746.4 м³ ус ашиглана.

1.6.3. Уурхайн цахилгаан хангамж

Уурхайн дээрх хэрэглэгчид нь 0.4 кВ-ын цахилгаан эрчим хүч хэрэглэнэ. Баяжуулах үйлдвэрт 300 кВА хүчин чадалтай дизель станц, далд уурхай нь 2 ам зэрэг ажиллах ба 1 аманд 200 кВА хүчин чадалтай станц, уурхайн тосгон болон бусад хэрэглэгчдэд 75 кВА хүчин чадалтай дизель станцыг сонгож авна.

Уурхайн дотоод цахилгаан хангамжийн хувьд баяжуулах үйлдвэрт 300 кВА хүчин чадалтай НҮW-300T5 маркийн дизель станц 1 ш, далд уурхайд 200 кВА хүчин чадалтай НҮW-200T5 маркийн дизель станц 2 ш-ийг сонгож хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангахаар тооцоолов. Уурхайн тосгоны болон бусад хэрэглэгчдийг 75 кВА хүчин чадалтай НҮW-75T5 маркийн дизель станцаас 0.4 кВ-ын цахилгаан эрчим хүчээр хангана.

Далд уурхайд 2 налуу ам зэрэг ажиллах учир 2 ш дизель станц шаардлагатай ба ерөнхий агааржуулалтын вентилятор, ус зайлуулах насос зэрэг нь 1-р зэргийн цахилгаан хэрэглэгчид учраас заавал 2 үүсгүүрээс тэжээх шаардлагатай. Иймд нөөцөд мөн 1 ш дизель станц байх шаардлагатай.

1.7. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

2026 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсанаар 25.0 мян.тн хүдэр олборлож,
баяжуулахаар төлөвлөсөн болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уул зүй: Галшар сумын нутагт орших Буянтын гянтболдын талбай нь Монголын зүүн өмнөд хэсгийн говь хээрийн бүсээс Хэнтийн уулархаг хэсэгт шилжих бүсэд оршдог. Байр зүйн хувьд талбай нь Хэнтий аймгийн өмнөд хэсэг, Сүхбаатар аймгийн баруун хойд хэсэг, Дорноговийн хойд хэсэгт хамаарна. Энэ нутгийн гадаргуу нь хагас цөлжсөн, дунд ба намхан толгодорхог, сулавтар хэрчигдсэн чулуурхаг хөрстэй усгүй тал нутаг юм. Дунд зэргийн уулархаг хэсэгт орших хамгийн өндөр цэг нь 1355м өндөр Суман уул, хамгийн нам дор цэг нь 1204м үнэмлэхүй өндөртэй. Нийт нутгийн дундаж үнэмлэхүй өндөр 1200-1300м бөгөөд харьцангуй зөрүү нь 100-150 м, нутгийн хойд хэсэг нь шовх оройтой хадан уулстай, хажуу хормой нь аажим тавиу налуутай зарим хэсгээрээ бул чулуун нурангатай. Харин нутгийн өмнөд хэсэг нь намхан толгодорхог бөгөөд үнэмлэхүй өндөр нь 1200м-ээс үл хэтэрнэ. Эндэхийн газрын гадаргуу нь нэлээд сайн тэгширсэн харьцангуй өндөршил нь 50-70 м, уулс нь янз бүрийн чиглэлтэй хуурай сайруудаар хэрчигджээ.

Цаг агаар, хур тунадас: Судалгааны талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг хамаарагдана. Энд жил сар, хоногийн температурын эрс өөрчлөлттэй. Жилийн хамгийн хүйтэн буюу -300 нь 1-р сар бөгөөд дунджаар -250, хамгийн халуун нь 7-р сард +350—370, дундаж халуун нь +200 байна. Жилийн 220 хоногт голдуу хасах температуртай байна. Хөрсний улирлын хөлдөлтийн гүн 1.9-2.4 м.

Ус зүй: Судалгааны талбай нь жилийн дөрвөн улирал ээлжлэн солигддог эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын температурын зөрүү их. Өвөл нь -35.7С хэм хүртэл хүйтэрнэ. Зун хамгийн их халж +35.3-өөс +40С хэм хүрнэ. Жилд унах хур тунадасны хэмжээ дунджаар 167.3 мм бөгөөд үүний 70 гаруй хувь нь зуны улиралд бууна. Жил бүрийн 10-р сарын сүүл үеэс цас орж хүйтний улирал эхэлдэг. Салхины хурд 3-5 м/сек-ээс 18 м/сек хүрнэ. Заримдаа түүнээс ч хүчтэй шороон шуурга шуурна. Гадаргын байнгын урсгалтай гол байхгүй. Судалгааны талбайн зүүн хойд хэсэгт 10 орчим жижиг нуур бий. Эдгээр нуур нь уулс хоорондын хотгорт байршдаг. Борооны улирлын явцад цэнгэг устай түр зуурын жижиг нуурууд үүснэ. Мөн үерийн уснаас шалтгаалж хөндийгөөр зорчих боломж 7-10 хоног алдагддаг.

Хөрс, ургамлын бүрхэвч: Агаар хөрсний чийгийн хангамжийг даган үлэмж сийрэг, тачир таруу ургадаг. Зонхилох ургамал нь бутлаг үетэн, шивээт, хялгана, хиаг, саман ерхөг, агь, хөмүүл, таана тааралдана. Хужир марзтай хонхор газруудаар дэрс, бударгана, лууль ургана. Тал хээрийн бүсийн экосистем ихээхэн эмзэг байдаг нь зүйлийн бүрэлдэхүүн цөөн, хөрсжилт нимгэн, усан хангамж тааруу, салхины нөлөө ихтэй, гангын давтамж өндөр зэрэгтэй холбоотой. Хөмүүл таана нутгийн брэнд бүтээгдэхүүн юм. Тал хээр бол Мал аж ахуй, Газар тариалангийн бүс нутаг юм.

Амьтны аймаг: Талбайн ихэнх хэсэг ой мод, өвсөөр тарчиг боловч талбайн хойт хэсэгт мод, модлог ургамлаас гацуур, хус шинэс, нарс, бургас, сөөгөн хус зонхилж ургаж байна. Тус нутагт махан идэшт агнуурын том амьтадаас чоно, үнэг, мануул, шилүүс, жижиг амьтдаас өмхий

хүрэн, цагаан үен, сүүн тэжээлтнээс буга, согоо, туулай, хэрэм, агнуурын шувуудаас ятуу, мэрэгчдээс мэхээрч оготно, ойн хөвхөлж элбэг тааралддаг.

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Хэнтий аймаг нь 77.6 мянган хүн амтай. Нийт хүн амын 50.5 хувь нь эрэгтэй, 49.5 хувь нь эмэгтэйчүүд тус тус байна. Хэнтий аймгийн хувьд хүн ам нь сүүлийн 5 жилийн турш тасралтгүй өсөж байна. Галшар сум нь 2200 орчим хүн амтай.

Сумын газар нутгаар дамжин өнгөрөх улсын чанартай автозам байхгүй. Багууд хоорондоо шороон замаар холбогддог. Цахилгаан хангамж. Галшар сумын төвийг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдох ажлын эхлэл 1989-1990 онд тавигдаж 15 жилийн дараа буюу 2004 оны 06 сарын 01-нд төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. Сумын төв дээр 2004 онд баригдсан 110/35/10 кВт-ийн дэд станц ажиллаж байгаа бөгөөд 2013 онд 0.4 кВт-ийн шугам татаж шинэ суурьшлын бүсийг цахилгаан хангамжид холбосон.

Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн 1 гүний худаг байдаг. Төвлөрсөн ус хангамжийн системд холбогдоогүй.

Сумын төвд төвлөрсөн уурын зуух байхгүй. ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын 9 жилийн сургууль, цэцэрлэг, Соёлын төвийн нийт 6 нам даралтын уурын зуух ажиллаж байна.

Хүн ам харьцангуй ихтэй, гол төлөв бэлчээрийн мал маллах, уул уурхайн үйлдвэрүүд болон төмөр замын өртөөнүүдэд ажил эрхэлдэг. Тус бүс нутаг нь өндөр хүчдэлд холбогдсон, төмөр замд холбогдсон, уулын баяжуулах үйлдвэртэй, дэд бүтэц сайн хөгжсөн ба эдийн засгийн хувьд таатай нөхцөл бүрдсэн нутаг юм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж

“Түмэн ивээл” ХХК-ийн “Буянт нэртэй гянтболдын ордыг далд уурхайн аргаар ашиглах” төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны арга, БОНХЯ-аас /хуучин нэрээр/ гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

3.2 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 9. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Будаж нөлөөлөх	Будалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны өөрчлөлт										
Агаарын чанарын өөрчлөлт	х				х		х	х		
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х		х		х	
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х		х	х		
Геологийн тогтоцын өөрчлөлт	х				х		х		х	
Зэрлэг амьтдын орон зай		х			х		х			х
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		х			х					х
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										
Бэлчээрийн байдал		х			х		х			х
Эрдэс түүхий эдийн нөөц	х				х		х	х		
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ										
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	х				х		х	х		
Хөрсний эвдрэл, бохирдол	х				х		х		х	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										

Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	х				х		х		х	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	х				х		х		х	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	х				х		х			х
Орон нутгийн орлого нэмэгдэх	х				х		х	х		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	х				х		х			х
Ажлын байр нэмэгдэх	х				х		х			х
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	х				х		х			х
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	х				х		х			х
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх	х				х		х		х	
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	х			х			х			х
Хүчтэй салхи, уруйн үер										
Дүн	17	3		1	19		19	5	6	9

Дээрх хүснэгтээс дүгнэхэд байгаль орчинд нөлөөлж болзошгүй шууд, урт хугацааны, буцалтгүй, бага зэргийн нөлөөлөл нилээд хувийг эзэлж байна.

Үүнд:

- ✓ Агаарын чанарын өөрчлөлт
- ✓ Ургамлын бүтцийн өөрчлөлт
- ✓ Хөрсний элэгдэл эвдрэл
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт
- ✓ Агаарын бохирдол
- ✓ Хөрсний элэгдэл, бохирдол
- ✓ Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх
- ✓ Орон нутгийн орлого нэмэгдэх
- ✓ Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- ✓ Ажлын байр нэмэгдэх
- ✓ Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
- ✓ Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
- ✓ Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
- ✓ Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавьж үржих зэрэг байна.

Дээрх болзошгүй нөлөөллүүдээс харахад эдийн засаг, нийгмийн асуудалд уурхайн үйл ажиллагаа шууд, урт хугацааны, буцалтгүйгээр нөлөөлөх эерэг нөлөөтэй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.

Алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон арилгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөх, түүнд зарцуулагдах зардлыг бодитой тооцоолох, байгаль орчны мониторинг хийхэд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд (БОМТ) тусгагдсан арга хэмжээг төсөл хэрэгжүүлэгч шат дараалалтайгаар хэрэгжүүлэх үүрэгтэй. Хамрах хүрээ БОМТ нь төслийн үйл ажиллагааны цар хүрээнд байгаль орчин, нийгэм хамгааллын дараах асуудлыг хамарч, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

- ✓ Төслийн хүрээнд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж холбогдох зардлыг тусгах,
- ✓ Төслийн хаалт нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж холбогдох зардлыг тусгах
- ✓ Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, зардлыг тусгах
- ✓ Осол, эрсдэл, аюултай нөхцөл байдлын үед хүрээлэн буй орчныг хамгаалах бодлогыг тодорхойлох
- ✓ Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг зааж, холбогдох зардлыг тооцох;
- ✓ БОМТ түүний хэрэгжилтэнд оролцогч талуудыг тодорхойлж, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин									
1	Уурхай орчимд тоосжилт үүсэх	Уурхайн ам орчимд болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Уурхайн гол болон тээврийн зам	км	200.0	0.8	160.0 x 25 удаа = 4 000.0	8-9-р сард	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт MNS 5916:2008
2		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу	ш	1 000.0	2	2 000.0 /ОХШХ/	Жилд 2 удаа, 8 болон 10-р сард	
Гадаргын ба газрын доорхи усны нөөц									
1	Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх	Ус ашиглах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах	Уурхай	-				8-р сард	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998.
2		Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх		-				10-р сард	
3		Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Гүний худаг	ш	250.0	4	1 000.0 /ОХШХ/	8 болон 10-р сард	
Хөрсөн бүрхэвч									
1	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах,	Овоолго	-				8-р сард	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. MNS 5916:2008 “Газар шорооны
		Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах	Шимт хөрсний овоолго						

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу						ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”
Газрын хэвлий									
1	Гянтболд олборлосноор газрын хэвлийд хоосон орон зай шинээр үүсгэнэ.	Уурхайн малталтууд болон олборлосон орон зайд бэхэлгээ, хамгаалалтын цул зэргийг үлдээж нуралт үүсэхээс сэргийлнэ	Далд уурхай		Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар			8-10-р сард	MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
Ургамлан нөмрөг									
1	Уурхайгаас олборлосон хүдрийг баяжуулах, хөрсний овоолго үүсгэх зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрс, овоолгын талбай			-		8-10-р сард	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт. Хадгалалт MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага
Амьтны аймаг									

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах	Үйл ажиллагааны турш		2 500.0			8-р сард	Амьтны тухай хууль: 6.1.3.амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах; 6.1.7.үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх;
2026 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын урьдчилсан дүн					9 500.0				

4.2. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлтийн хөрөнгө	ш	1	106 100.0		10-р сард	MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
2	Биологийн нөхөн сэргээлт	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	ш	2500	20.0	75 000.0	10-р сард	
3	Татан буулгах, хаалтад бэлтгэх	-	-	-	-	-	-	-
Нийт						181 100.0		

4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 12. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах	Шинэ худаг гаргах, одоо байгаа малчны худгийг сэргээн засварлах замаар шийдвэрлэх	Хэнтий аймгийн байгаль орчны газартай хамтран сонгосон талбайг	1	10 000.0	10 000.0	9-р сард	
Нийт						10 000.0		

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө*Хүснэгт 13. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө*

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2026 онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.							

4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*Хүснэгт 14. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал	Уурхай орчимд археологийн дурсгал илрээгүй болно.						
2	Палеонтологийн дурсгал	Уурхай орчимд палеонтологийн дурсгал илрээгүй болно.						

4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*Хүснэгт 15. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гал түймэр	Галын булан байрлуулах	Уурхай	1	1000.0		2026 онд	
Нийт					1 000.0			

4.7. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал*Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө*

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлыг түр хадгалах цэгийг тохижуулах	Уурхай	ш	1 000.0	1	1 000.0	8-р сар	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдлын гэрээ байгуулж, тогтмол тээвэрлүүлэх	Уурхай	сар	250.0	2	500.0	9-10-р сард	
Нийт				1 500.0					

4.8. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанарын болон дуу шуугианы хэмжилт хийх, хөрсний болон усны шинжилгээ хийлгэх ажлыг төлөвлөсөн бөгөөд уг ажлыг гүйцэтгэх явцдаа нөлөөллийн бүсийн иргэд, орон нутгийн төлөөллийг байлцуулах шаардлагатай.

Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар				
SO ₂ , NO ₂ , CO, Тоос,	Уурхайн амууд, гол зам, тосгон орчим 3 цэгт	Жилд 2 удаа, 8 болон 10-р сард	1 000.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаар бохирдуулагч бодисуудын ялгарлын хэмжээ	Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд	Жилд 1 удаа, 10-р сард	1 000.0	MNS 5013:2003 Бензин хөдөлгүүртэй автомашин, утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2003 Дизель хөдөлгүүртэй
Дуу шуугиан				
Дуу шуугиан, чичиргээ	Уурхайн талбай, тоног төхөөрөмж, ажлын байранд 3 цэгт	Жилд 2 удаа, 8 болон 10-р сард	500.0	MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
	Авто тээврийн зам дагуу	, Жилд 2 удаа, 8 болон 10-р сард		MNS 5002:2000 Шуугианы норм, аюулгүй ажиллагаа MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний нефть бүтээгдэхүүний бохирдол	Уурхайн гол зам, тосгон орчим 2 цэгт	Жилд 1 удаа, 10-р сард	500.0	MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. MNS 3297:1991 Хот суурин газрын хөрсний ариун Ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм хэмжээ
Усан орчин				
Унд ахуйн зориулалтаар ашиглах усны pH, TDS, нийт хатуулаг, исэлдэх чанар, Ca, Mg, Na, K, NH ₄ , нийт Fe, HCO ₃ , Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , амт, үнэр, өнгө, тунгалаг чанар, эрдэсжилт г.м	Уурхайн унд ахуйн хэрэглээний усыг авдаг худаас	Жилд 1 удаа, 10-р сард	1 000.0	MNS ISO 5667-1 : 2002 Усны чанар. Дээж авах 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар MNS ISO 5667-3 : 2019 Усны чанар. Дээж авах. 3-р хэсэг: Усны сорьцтой харьцах ба сорьцыг тогтворжуулах
Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн зардлын урьдчилсан дүн			4 000.0	

4.9. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			8-р сар	9-р сар	10-р сар		
1	Уурхайн бэлтгэл ажлыг бүрэн хангах	-				Уурхайн дарга	
2	УАТөлөвлөгөө болон БОМТ-г боловсруулан батлуулах	-				Ашиглалтын инженер, БО-ны мэргэжилтэн	
3	БОМТ-нд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх	БОМТ-ний зардлаар				Байгаль орчны мэргэжилтэн	
4	Ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах	3 000.0				Уурхайн дарга	

4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 19. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа	Зардал
1	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдлыг танилцуулах	Хэнтий аймгийн БОГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	VIII сард	1 000.0 мян.төг
2	Уурхайн үйл ажиллагааны тухай тайлан мэдээг орон нутгийн албан ёсны цахим хаягаар танилцуулах, иргэдийг мэдээллээр хангах	Төслийн нөлөөллийн бүсийн иргэд, сумын иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	X сард	
3	Нийт хийгдсэн ажлын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлагнал	Хэнтий аймгийн БОГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	X сард	

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 211.1 сая төгрөгийг төлөвлөж өглөө. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд 9.5 сая төгрөг, нөхөн сэргээлтийн зардалд 181.1 сая.төг, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд 10.0 сая.төг, хог хаягдлын менежментийн арга хэмжээний зардалд 1.5 сая.төг, ОХШХ-т 4.0 сая төг, осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд 1.0 сая.төг, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд 3.0 сая.төг, төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах ажилд 1.0 сая.төг зарцуулахаар тооцсон болно.